

2019 ОНЫ 12 САР

Эрүүгийн хэргийг шүүхээс буцаах эсэх асуудлаар нийгэмд өрнөж буй хэлэлцүүлэгт хувь нэмэр оруулах зорилгоор “Эрүүгийн хэргийг шүүхээс буцаах нь буруу” сэдвийн хүрээнд зарчмын өөр байр суурь бүхий мэргэжилтнүүдийн оролцоотой энэ удаагийн “Үзэл бодол” цуврал хэлэлцүүлгийг зохион байгуулж, хэлэлцүүлгийн тэмдэглэлийг толилуулж байна.

АРГА ЗҮЙ

ННФ-ын Монголын хуульчдын холбоотой хамтран зохион байгуулж буй “Үзэл бодол” цуврал хэлэлцүүлгийн зорилго нь эрх зүйн шинэтгэлийн хүрээнд маргаан дагуулж буй асуудлыг эсрэг тэсрэг байр сууринаас авч үзэн хэлэлцэх, мэдээлэл солилцох, тухайн асуудлын талаарх үндсэн ойлголтыг гүнзгийрүүлэх, улмаар олон нийтэд нэг талыг барьсан биш, аль болох тэнцвэртэй мэдээлэл хүргэх, олон улсын туршлага, хүний эрхийн хэм хэмжээний талаарх мэдлэгийг тэлэх боломж олгоход оршино. Хэлэлцүүлэг гурван хэсгээс бүрддэг бөгөөд эхний хэсэгт зарчмын зөрүүтэй байр суурьтай хоёр зочин өөр өөрийн байр суурийг илэрхийлж, харилцан мэтгэлцдэг бол хоёр дахь хэсэгт тухайн асуудлаар олон нийт болон бодлогын хүрээнд өрнөж буй хэлэлцүүлэг, холбогдох байр суурь, баримт материалыг зохион байгуулагчдын зүгээс тоймлон хүргэдэг болно. Улмаар хэлэлцүүлгийн бусад оролцогч мэтгэлцэгч талд асуулт тавих болон өөрсдийн байр сууриа илэрхийлэх замаар хэлэлцүүлэг өрнөдөг. Төгсгөлд нь зохион байгуулагчдын зүгээс хэлэлцүүлгийн туршид гарсан гол асуудлыг дүгнэн, хэлэлцүүлгийн тэмдэглэлийг хэвлэн нийтэлж, олон нийтийн хүртээл болгодог билээ.

ЭРҮҮГИЙН ХЭРГИЙГ ШҮҮХЭЭС БУЦААХ НЬ БУРУУ

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд өрнөж буй маргаан бүхий асуудлын нэг бол шүүхээс хэрэг буцаах тухай билээ. Эрүүгийн хэргийг шүүхээс буцаахгүй байх тухай зохицуулалт нь эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн гол өөрчлөлтүүдийн нэг юм. Энэ тухай Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн танилцуулгад “...шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн тогтолцоог бий болгосноор шүүхээс прокурорт хэрэг буцаахгүй байхаар тусгасан. Ингэснээр Үндсэн хууль болон энэ хуульд заасан гэм буруугүйд тооцох зарчим хэрэгжих боломж бүрдэх юм” хэмээн дурджээ.

Ийнхүү 2017 онд шинээр баталсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар эрүүгийн хэргийг шүүхээс буцаахыг хориглосон атал гэм буруугийн шүүх хуралдаанаас эрүүгийн хэргийг буцаах шийдвэр гаргаж байгаа нь Хууль зүйн үндэсний хүрээлэн (ХЗҮХ)-гийн хуулийн хэрэгжилтэд хийсэн судалгааны дүнгээс харагдаж байна. Хэдий хуулийн зохицуулалт буруу, эсвэл оновчтой бус байлаа ч хуулийг нэг мөр хэрэглэх субъектийн зүгээс хуулийг хэрэглэхгүй байх нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан хууль дээдлэх зарчмыг алдагдуулж байгаа явдал юм. Тиймээс хэлэлцүүлгийн сэдэв маргаантай байгаад зогсохгүй хуулийн хэрэгжилтэд тулгарч байгаа нэг томоохон зөрчилтэй зохицуулалт болохыг батлан харуулж байна.

МЭТГЭЛЦЭГЧ ТАЛУУДЫН БАЙР СУУРЬ



Т.Оюунчимэг, док., проф., цагдаагийн хурандаа, ДХИС-ийн ЭШНХ-ийн Цагдаа судлалын төвийн ЭША. ОХУ-ын Санкт Петербургийн ДЯЯ-ны Их сургуульд “Гүйцэтгэх ажлын үр дүнг ЭБШ ажиллагаанд ашиглах нь” сэдвээр докторын зэрэг хамгаалсан ба ХСИС-д ахлах багш, тэнхимийн эрхлэгчээр ажиллаж байсан.

ХУУЛЬЧ Т.ОЮУНЧИМЭГ: ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЗАРЧМЫГ БАРИМТАЛДАГ Л БОЛ ХЭРГИЙГ БУЦААХ ЁСГҮЙ.

Эрүүгийн хэргийг шүүхээс буцаах нь буруу юм. Шүүх дээр хэрэг очихоос өмнө эрүүгийн хэргийн мөрдөн шалгах төрийн механизм ажиллаж байгаа бөгөөд хангалттай гэж үзээд шүүхэд шилжүүлж байна. Мөрдөн байцаалт дутуу хийгдсэний улмаас буцаах шаардлага гардаг. Энэ нь олон улсын хэм хэмжээ болон Үндсэн хуулийн зарчим зөрчигдөхөд хүргэж байна. Шүүх нь тухайн хэргийг үйлдсэн эсэхийг хэлэлцэж шийдвэр гаргах ёстой.

Хууль дээдлэх зарчимд захирагдах юм бол хэргийг буцаах ёсгүй.

Шүүх хэргийг мэтгэлцээний үндсэн дээр явуулна гээд ЭХХШТХ-д заасан. Гэтэл шүүх талуудын мэтгэлцээн хангалтгүй гэж үзээд буцааж байгаа нь буруу. Прокурор хариуцлагаа хүлээх ёстой.

Прокурор өмнө нь мөрдөн шалгах ажиллагаанд хяналт тавих үүрэгтэй байсан бол одоо “мөрдөн шалгах ажиллагааг удирдан зохион байгуулах” үүрэгтэй болсон. Тиймээс мөрдөн шалгах үе шатны талаар бүхэлд нь цогц ойлголт, мэдлэгтэй байх ёстой. Мэдлэг муугаас үүдэн шинжээчээр өөрөөр хэлбэл, өөрсдөө чадахгүй зүйлээ хэн нэгнээр хийлгэх гээд байна.



Б.Батзориг, док., дэд проф., Санхүүгийн зохицуулах хорооны ЗУГ-ын дарга. МУИС-ийн ХЗС-д “Эрүүгийн хэргийн нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх ажиллагааны онол практикийн асуудал” сэдвээр докторын зэрэг хамгаалсан. Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд процессын хуулиудын ажлын хэсгийн гишүүнээр ажиллаж байсан.

ХУУЛЬЧ Б.БАТЗОРИГ: ТОГТОЛЦОО БЭЛЭН БИШ, ШҮҮХЭЭ ХАМГААЛЖ ЧАДАХГҮЙ БАЙГАА ҮЕД ШҮҮХЭЭС ХЭРЭГ БУЦААХ НЬ ЗӨВ.

Хэргийн бодит үнэн тогтоогдоогүй байна гэж үзэн буцааж байгаа бол зөв юм. (i) Хуулийн, хууль сахиулах байгууллагын сэтгэлгээ хуучин хэвээр байна. Хуульчид 20-30 жил ялах талыг барьж ажиллаж ирсэн. (ii) Олон нийт шударга ёсыг шаардаж байна. Нүдэн дээр нь гэмт хэрэг үйлдсэн хүнийг шүүх цагаатгахаар олон нийт хүлээж авч чадахгүй байна. (iii) Хууль хяналтын байгууллагын нэр хүнд муу, авлигад автсан зэргээр нэр хүнд нь унаад байгаа энэ үед шүүхээс хэргийг буцаалгүй шийдвэр гаргах нь эрсдэлтэй. Хэрэв цагаатгасан шийдвэр гаргавал эсрэгээр нь шүүхийг буруутгах үндэслэл болоод байна.

Тогтолцоо бэлэн биш, шүүхээ хамгаалж чадахгүй байгаа үед шүүхээс хэргийг буцааж байгааг зөв гэж үзэж байна.

Хэргийг дутуу шалгах ёсгүй, мэдлэгтэй байх ёстой гэдэгтэй санал нэг байна. “Хууль ёсны зарчим” бол миний докторын ажил. Мэдүүлэгт тулгуурлан нотлох ажиллагааг явуулж байгаа нь асуудалтай. Гэтэл мэдүүлэг маш их өөрчлөгддөг. Шинэ процессын хууль бол гагцхүү мэдүүлэгт биш аль болох хөдөлшгүй нотлох баримтаар нотлох ажиллагааг явуулах ёстой.

Шинжлэх ухааны өргөн хүрээтэй мэдлэг, практик туршлагагүйгээс болж л хэргийг дутуу шалгаж, үүний улмаас шүүхээс хэрэг буцаах тухай яригдаж байна. Ер нь бол мөрдөн шалгах ажиллагааны хяналтыг өөр субъектэд шилжүүлэх ёстой.

Шинжлэх ухааны үндэслэлгүй хууль баталсантай “хэргийг шүүхээс буцаахгүй” гэсэн хуулийн заалт хэрэгжихгүй байгаа нь холбоотой юу?

Хуулийг чанд мөрдүүлэх ёстой. Намайг өнөөдөр яах бол гэж ажиллавал ажил явахгүй.

Яагаад энэ их айдас, маргаан гараад байна гэхээр хуулиуд хоорондоо уялдаагүй, авцалдаагүй байна.

Гэтэл хуулийн төсөл бичсэн залуучуудын шинжлэх ухааны мэдлэг хангалтгүйгээс хууль нь бодитой биш байна. Ачааллыг нь хэт ихэсгээд үүнээс болоод мөрдөгчид шантарч байна. Бусад орны сайн туршлагыг нэвтрүүлж болох ч өөрийн орны үндэстний онцлог, соёлд тааруулж, зөв нутагшуулах ёстой. Мөн сайн судлах хэрэгтэй. Судалгааны үндсэн дээр л хийх ёстой. Хуульд алдаатай зүйл их байгаа нь үндсэн шалтгаан болж байна.

Мөрдөгч нар хуучин хандлагаар хандаж байна. ЭХХШТХ бол хууль сахиулагчдын ачааллыг бууруулах, тэдний эрхийг хамгаалдаг хууль биш. Гэтэл шинэ хуулийн орчинд хуучин хандлагаар ажиллаж байна. (i) ачаалал, (ii) “арьсаа хамгаалдаг” гэдэг нь үнэн. Ажлын ачаалал их байгаа тул мөрдөгч прокурорт, прокурор шүүхэд шилжүүлнэ. Ер нь шүүгчийн арга барилаас хамаарч практик тогтодог. 1949 оны процессын хуулиас эхлээд шүүгчид “хэргийн бодит үнэнийг тогтоо” гэсэн үүрэг ногдуулсан. Болохгүй бол буцаа гээд. Яг энэ зарчмаар хагас 100 жил явсан. Тиймээс энэ нөхцөл байдалд эрх зүйн хамгаалалт бий болгох, ажиллах нөхцөлөөр хангах, сэтгэлгээг өөрчлөх шаардлагатай. Тиймээс энэ үед буцаах нь зөв.

Өнөөдөр тулгарч байгаа асуудлыг хэзээ шийдэгдсэн гэж үзэж, энэ шийдвэрийг хэрэгжүүлэх вэ?

2003 онд докторын ажилд зориулж 2002 оны хууль хэрэгжсэнээс хойш 5 сарын дараах дүнг улсын хэмжээнд судалсан бол 2015 оны хууль хэрэгжсэнээс хойш 1 жилийн дараа нийслэлийн хэмжээнд судалгаа хийсэн. 2002 оны хууль батлагдахад хуулийг барьдаггүй байв. 1963 оны хууль бол ямар ч судалгаагүй, оросын процессын хуулийн шууд хуулбар бөгөөд тэр үед бүх социалист орон адил байсан. Харин 1927, 1935, 1949 оны хууль бол арай өөр. Одоогийн нөхцөл байдал 2003 оныхтой ижил. Яагаад хэрэгжихгүй байна гэхээр 94 хувь нь шинэ хуулиар огт сургалт явуулаагүй, 72 хувь нь хуулийг судалж амжаагүй, 48 хувь нь хуулийн олдоц муу, 39 хувь нь хуулийн нэгдсэн ойлголт байхгүй гэж хариулж байв. Тэгвэл 2016 оны судалгаагаар 95 хувь нь хуулийн нэгдсэн ойлголт байхгүй гэж хариулсан байна.

Бусад гэсэн асуултад энэ системд угаасаа энэ хууль болохгүй, хууль өөрчлөгдөнө гэсэн хүлээлт байна, өнөөдөр шүүгч, прокурор нийлээд суухад хуулийг өөр өөрөөр ойлгож байна. Багш нар хичээл заахдаа энэ хууль муу гээд заадаг. Ер нь хуулийг үг дуугүй хэрэгжүүлэх ёстой хүмүүс хуулийг нэг мөр хэрэгжүүлдэг болсон цагт л энэ зохицуулалт хэрэгжинэ. Өнөөдөр заал дүүрэн хүний өмнө хоёр шүүгч энэ хууль таалагдахгүй байгаа тул хэрэгжүүлэхгүй гэж хэлээд сууж чадаж байна. “Хуулийг хэрэгжүүлэхийн тулд баталдаг болохоос шүүмжлэхийн тулд баталдаггүй” гэсэн Б.Чимид гуайн үг ч бий. Тиймээс хуулийг хэрэгжүүлэх ёстой хүмүүс шүүмжлэх биш хэрэгжүүлэх ёстой.

Хэлэлцүүлгийн сэдвийн хүрээнд гарч буй зарчмын зөрүүтэй байр суурийг баримт, судалгаанд үндэслэн нэгтгэж харуулбал:¹

ХЭРГИЙГ БУЦААХ НЬ БУРУУ

- Шүүх хөндлөнгийн, хараат бус байр сууринаас хэргийг хянан шийдвэрлэх зарчимтай зөрчилдөнө.
- Шүүх яллах байр сууринаас асуудалд хандаж байна.
- Дэлхийн улс орнууд шүүхээс хэрэг буцаахаас татгалзаж байна.
- Шүүхээс хэрэг буцсан шалтгааны 70 хувь нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт бүрэн биш хийсэн, шүүх хуралдаанаар нөхөн гүйцэтгэх боломжгүй гэсэн үндэслэл байгаа нь мөрдөгч, прокурор шүүхээс чиглэл авч ажиллах хандлагыг бий болгож байна.
- Гэм буруугийн зарчимтай зөрчилдөнө.

ХЭРГИЙГ БУЦААХ НЬ ЗӨВ

- Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан “шүүхийн хараат бус байдал”-ын зарчмыг зөрчсөн.
 - Шүүхийн тухай хуулийн “Шүүхийн бие даасан байдлын зарчмыг алдагдуулсан, дордуулсан хууль тогтоомж болон захиргааны акт гаргахыг хориглоно” гэсэн зарчмыг зөрчсөн.
- VS**
- Шударга шийдвэр гаргах нөхцөлийг хумьж, шүүхийн эрх хэмжээг дордуулсан. Бүрэн бус мөрдөн шалгах ажиллагаа явуулсныг мэдсээр байж үндэслэлгүйгээр цагаатгасан, ялласан шийдвэр гаргаж нийтийн эрх ашиг хохирох, шударга ёсыг гажуудуулахад хүрч байна.
 - “Double jeopardy” зарчим зөрчигдөхөд хүрнэ.
 - Яллагдагчид хуулиар олгогдсон эрхийг бүрэн бодитой эдлүүлж чадахгүй байгаа нөхцөлийг залруулж чадахгүйд хүрнэ.

Хуулийн зарим байгууллага шүүхээс хэрэг буцаахгүй байх талаар стратегийн баримт бичигтээ зорилт болгон тусгасан байна. Тухайлбал, Прокурорын байгууллагын 2011-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт “...Шүүхээс хэрэг буцаах журмыг бүрэн халах талаар судалгаа хийж, санал боловсруулах” тухай дурджээ.


Хууль зүйн үндэсний хүрээлэн (ХЗҮХ)-гийн хийсэн судалгааны дүнгээс харахад шүүхээс хэрэг буцаах асуудлыг буруу гэж зөвхөн

судлаачдийн дийлэнх үзжээ (График 1-ийг харна уу). 2017 оны судалгаанд хамрагдсан процесс ажиллагаанд оролцогчдын 87.7 хувь нь шүүхээс эрүүгийн хэргийг буцаах нь зөв гэж хариулсан бол, 2018 оны судалгаагаар шүүгчдийн олонх буюу 90 хувь нь зөв гэж үзсээр байсан бөгөөд прокурорын санал буурч 34 хувь болжээ.

¹ Б.Батцэрэн, УДШ-ийн шүүгч, “Эрүүгийн хэргийг прокурорт буцаах шүүхийн эрх хэмжээ” нийтлэл, <http://www.supremecourt.mn/news/404> (2019.05.05), 2018 он, ХЗҮХ-ийн “Шүүхээс эрүүгийн хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр прокурорт буцаах нь” сэдэвт судалгааны тайлан 2017 он, Чингисийн хууль ХХН, <http://www.chinggislaw.com> (2019.05.05)

ТЭЛЦҮҮЛГИЙН ТОЙМ

График 1. Шүүхээс эрүүгийн хэргийг буцаах нь буруу?



Шүүхээс хэргийг буцаах эсэх асуудал нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 14-р зүйл буюу шударга шүүхээр шүүлгэх эрхийн хүрээнд хамаарах асуудал юм. Хэлэлцүүлгийн сэдэвт хамаарах агуулгыг тодруулбал:

1. Гэм буруугүйд тооцогдох: Холбогдох албан тушаалтан хэн ч бай шүүхээр хэрэг шийдэхээс өмнө үр дүнгийн талаар урьдчилан дүгнэлт гаргахаас түдгэлзэх, гэм буруутай мэт олон нийтэд мэдээлэхгүй байх;

2. Зүй бусын хойшлуулалтгүйгээр шүүгдэх: Хэргийн ээдрээ төвөгтэй байдалд тулгуурлан хугацаа ялгаатай байх боловч, шүүхийн бүхий л шатанд хэргийг зүй бус хойшлуулалтгүйгээр шийдвэрлэх ёстой;

3. Үйлдсэн гэмт хэрэгтэй тухайн улсын хууль болон эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу эцэслэн шийтгүүлсэн буюу цагаатгагдсан хэнийг ч тэрхүү гэмт хэргээр нь дахин шүүх буюу шийтгэх ёсгүй.

Шүүхээс хэргийг буцаахгүй байх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгаж байх үед ч мөн улс төрчдийн зүгээс зөрүүтэй байр суурь илэрхийлж байсан болно.²

Ж.Батзандан: “Шүүхээс хэрэг буцаахгүй байх нь хүний эрхийн том дэвшил, өмгөөлөх, яллах талын мэтгэлцэх зарчим тэнцвэржинэ.”

О.Баасанхүү: “Шүүх прокурорыг ажлаа хийгээгүйн төлөө хэргийг буцаах ёсгүй.”

М.Оюунчимэг: “Прокурор анхнаасаа буруутай, үгүйг нь тогтоогоод шүүхэд шилжүүлэх хэрэгтэй. Буцаах болвол прокурор нь шүүхийнхээ дээр гарна.”

Д.Лүндээжанцан: “Хэргийг буцаахгүй болсноор хуулийн байгууллагын ажлыг сайжруулахад том алхам болно.”

VS

Х.Нямбаатар: “Хохирогчийн талаас асуудалд хандах хэрэгтэй.”

Н.Учрал: “Бодит байдлыг тогтоох нь гол зорилт тул нотлох баримт хангалтгүй байвал шүүхээс прокурорт буцаах ёстой.”

² Чингисийн хууль ХХН, Байр суурь: Хэргийг шүүхээс нэмэлт мөрдөн байцаалтад буцаахгүй талаар хэн юу хэлэв, <http://www.chinggislaw.com> (2019.05.05), <http://vip76.mn/content/46736> (2019.05.15)

ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ ОРОЛЦОГЧДЫН БАЙР СУУРЬ

Хэлэлцүүлгийн явцад оролцогчдын зүгээс дор дурдсан асуудлыг хөндсөн нь оролцогчдын байр суурьт тусгалаа олсон болно.

- Эрүүгийн эрх зүйн шинэчлэл явагдсанаар санхүүжилт хэр нэмэгдсэн бэ?
- Мэдүүлэгт үндэслэж шийддэг байсныг нотлох баримтад тулгуурлаж шийдэх болсноор ажлын ачаалал, цаг хугацаа, санхүүжилт нэмэгдэх нь тодорхой. Хуульд нэмэлт, өөрчлөлт ороод хэргийг буцаадаг болбол энэ нь шинэчлэлийн үзэл баримтлалтай уялдах уу?
- Шүүхээс хэрэг буцааснаар өмгөөлөгчид хэрэгтэйгээ илүү танилцах, үйлчлүүлэгчээ илүү сайн өмгөөлөх боломж бүрдэх үү?

БУЦААХ НЬ БУРУУ

МУИС-ийн ХЗС-ийн Док., Дэд проф. Ж.Эрхэсхулан:

Шүүх хэрэгжүүлээгүй гэж байгаа ч бүгд биш. 60 гаруй цагаатгасан шийдвэр гаргасан нь үүнийг баталж байна. Шүүгч сэтгэлгээгээ өөрчлөх ёстой. Хүний эрхийг хамгаалах ёстой. Процесст тэнцвэргүй талууд оролцдог. Манай уламжлал бол төр яллах бодлого баримталж ирсэн. Тиймээс тэнцвэргүй талуудын эрх хэмжээг тэнцвэртэй болгоход чиглэх ёстой. Өмгөөлөгчид зэвсэг байхгүй. Хуульд 10 хүрэхгүй тооны эрх байгаа ч шүүхийн өмнөх шатанд тэнцвэргүй явж ирсэн. Тиймээс шүүхийн шатанд тэнцвэрийг хангая гэж энэ хуульд оруулж ирсэн. Яллах, өмгөөлөх тал гэж чиг үүргийг хуваагаад шүүгч хоёр талын мэтгэлцээнд тулгуурлаад шийдэх нь зүйтэй гэсэн. Шүүх яллах талаас харж бүгдийг зохицуулж байна. Чиг үүргээ хуваасан тул шүүх дээрээс хараад мөрдөн шалгах ажиллагаа дутуу хийсэн гэж шийдэж байгаа нь буруу. Шүүхээс буцааж байгаа нь үр дагавартай. Буцаах нь шүүгдэгчийн эрхийг хамгаалахын тулд гэж шударга ёсны зарчим ярьдаг. Адил хэрэгт өмнө нь хүнд ял оноочоод байхад прокурор бага ял оруулаад ирлээ гэдэг. Эдгээр үндэслэлийг сонсохоор харгалзаж үзэхээр байгаа ч процесс ажиллагааны оролцогчид өөр өөрсдийн чиг үүргийг л гүйцэтгэх хэрэгтэй байна. Бодит үнэнийг тогтоох зарчим хуульд туссан. Энэ нь мэтгэлцэх зарчимтай уялдаж байгаа. Шүүх нь талуудын мэтгэлцээнд үндэслэн бодит байдлыг тогтооно гэсэн байтал харин эсрэгээрээ байна.

МХХ-ны зөвлөлийн гишүүн, өмгөөлөгч Б.Ганбаатар:

Иргэн талдаа чухал сэдэв шүү. Монгол Улсын Үндсэн хуулиар шүүх гэм бурууг шийдэх дархан эрхтэй. Шүүгчийн сэтгэлгээ болж өгөхгүй байна. Шүүх гэм бурууг хэлэлцэж эхэлсэн бол эцэслэн шийдэх ёстой. 55 жил хэрэг буцааж ирлээ. Одоо дахиад хэдэн жил хэрэгтэй юм бэ? Буцаах тохиолдол байна гэвэл анхан шатны шүүх илэрхий алдаа гарсныг буцаахаар зохицуулж болох юм. Хүний эрхийн холбоотой асуудлаар хуулийг өөрчлөхдөө хүмүүсийн санал авдаггүй. Миний хувьд буцаадаг системдээ буцвал шинэчлэл биш шүү гэдэг байр сууриа илэрхийлсэн. Гэтэл өмгөөлөгчдийн байр суурийг сонсоогүй. Ер нь иргэн талдаа л шийдвэр гаргах ёстой. Шүүхээс хэрэг буцаадаг болбол эрүүгийн шинэчлэлд асар том ухралт болно. Энэ асуудлыг шийдэхдээ иргэдийг суулгаад ярих шаардлагатай.

БУЦААХ НЬ ЗӨВ

МХХ-ны Ерөнхийлөгч Ж.Хунан:

Буцаах нь зөв гэсэн байр суурьтай байна. Судалгаанаас харахад судлаачид, эрдэмтэд л буцаах нь буруу гэдгийг зөв гэж үзэж байна. Гэтэл практикт хүмүүс бодит байдлыг үнэлж байр сууриа хэлж байгаа тул үүнийг анхаарах хэрэгтэй. Хоёрт, шүүхээс хэргийг буцаахаа боливол прокурорын ажлыг үнэлэх боломж хязгаарлагдана. Хэмжээ хязгаартай байх ёстой. Шүүх шударга үнэнийг тогтоох ёстой. Шүүх бол ял өгдөг механизм биш.

МХХ-ны зөвлөлийн гишүүн, өмгөөлөгч Д.Нямдорж:

21 жил өмгөөлөгчөөр ажиллаж байна. Шүүхээс хэрэг буцаах нь зөв гэсэн байр суурьтай оролцож байна. Би гал дундуур нь явж байна. Өнөөгийн нөхцөл байдал энэ хууль хэрэгжих боломжгүй. Өнөөдөр шадар сайд нь нэг асуудлыг гаргаж ирээд одоо шүүх нь яаж шийдэхийг харъя гээд сууж байна. Нийгмийн сүлжээгээр ярьж байгаа сэтгэгдлүүдээр ял оноож байна.

МХХ-ны зөвлөлийн гишүүн, өмгөөлөгч Ж.Батзоригт:

Мөрдөн байцаалтад буцаах нь буруу. Надад 3 хэрэг байна. Нэг хэрэг гэхэд 12 жил болж байна. Сая хөөн хэлэлцэх хугацаа нь дууслаа. Энэ бол тод жишээ. Саяхан хүний банканд барьцаалагдсан 158 хөрөнгийг давхар барьцаа хийгээд шүүхэд шилжүүлэх гээд орж ирж байна. Шинэ процессын хуульд урьдчилсан хэлэлцүүлэг гэсэн чухал механизм орж ирсэн. Урьдчилсан хэлэлцүүлэг дээрээ л прокурор, мөрдөгчийн алдаатай холбоотой асуудлаа ярих ёстой. Энэ үе шатанд дээрх давхар битүүмжилсэн асуудал яригдаад хэргийг буцаасан чинь прокурор эсэргүүцэл бичээд явж байна. Тэр үйлдэлтэй нь холбогдуулаад банкнууд гуравдагч этгээдээр нэхэмжлэлээ гаргаад явж байна. Ер нь хуульд процессын алдаатай зохицуулалт байгаагаас болж мөрдөгчөөс ч, прокуророос ч хамааралгүй алдаа гарч байна. Улсын яллагч тогтоож чадахгүй бол шүүх цагаатгах хэрэгтэй. Шүүгчийн дотоод итгэл гэж чухал зүйл байна.

Өмгөөлөгч Л.Түвшинцэнгэл:

Процессын нэг л асуудал байна. Мөрдөгчтэй адил өмгөөлөгч нотлох баримт бүрдүүлээд явдаг бол ийм асуудал гарахгүй. Одоо тийм биш тул яалт ч үгүй нөхөн гүйцээх ажиллагаа хийх шаардлагатай тул буцаах шаардлага гардаг. Урьдчилсан хэлэлцүүлгээс буцаах боломж байгаа тул хуульчид, хууль сахиулагчид хуулийг нэг мөр ойлгодог байх шаардлагатай.

Хуульч Б.Батзориг:

Шүүхээс буцаах шийдвэр шинэтгэлтэй яаж уялдах вэ? гэхээр ямар ч ноцтой хэрэг байсан иргэний зориг гаргаад цагаатгах ёстой. Хэрвээ эр зориг гаргаж чадахгүй бол шинэчлэл хэрэгжихгүй. Санхүүжилтийн тухайд хүний нөөц дутмаг, хууль зардалтай гэж байна. Процессын хууль бол амар хялбар аргаар хүнийг яллах хууль биш ээ. Шинэчлэлийн дүнд илүү зардал гарахаар хийсэн. Өндөр зардлаар хэрэг маргааныг шийдэх үү, гэмт хэргээсээ урьдчилан сэргийлэхэд хөрөнгө зарах уу гэдгийг хуульчид, хууль сахиулагчид шийдэх ёстой. Хуульд хялбаршуулсан журмаар хэргийг шийдэх шинэ журам оруулсан. Хэдийгээр хэргийн тоо өндөр байгаа ч хэргийн нөхцөл байдлыг шинжилбэл 80 орчим хувь нь энгийн үйлдэлтэй хэрэг байдаг. Тиймээс буруутай этгээд хэргээ хүлээвэл өдөрт нь ч шийдэх боломжтой. Энэ журмыг хэрэгжүүлээд эхэлбэл хэргийн ачаалал буурч, илүү хүнд, ноцтой хэрэг дээр төвлөрч ажиллах боломж бий болно.

Өмгөөлөгч Б.Ганбаатар:

Буцааснаар өөрчлөгдөхгүй. Хэргээ шалгаж байна гээд хөзрөө нуудаг. Зарим тохиолдолд залуу өмгөөлөгчдийн хувьд боломж бүрдэхийг үгүйсгэхгүй. Гэхдээ сүүлийн үед өмгөөлөгчид багаар ажилладаг болсон. Харин прокурор, мөрдөгчийн алдаа бол дуусахгүй.

МУИС-ийн ХЗС-ийн Доктор, Дэд профессор Ж.Эрхэсхулан:

Мөрдөн шалгах ажиллагаа хаалттай тул буцаавал хүний эрх сэргэх биш, ял нь батлагдаад, нотлогдоод ирдэг тоо нь хамаагүй их байдаг. Шүүхийн өмнөх шатанд өмгөөлөгчийн эрхийг нээгээд өгвөл энэ хүмүүс хяналт тавиад буцаах шаардлага гарахгүй.

Өмгөөлөгч нотлох баримт цуглуулна гэснээ хуульд оруулаагүй. 60 хавтаст хэргийг хоёр цагийн дотор танилц гэдэг. Эсхүл танилцуулна гэххээд шүүхэд шилжүүлчихдэг. Ийм үед шүүхээс хэргийг буцаах нь зөв.

Өмгөөлөгч Ч.Өнөржаргал:

Шүүхээс хэрэг буцаах нь зөв. Буцаахгүй шийдвэл цагаатгах тоо өндөр гарах байх. Яллах талын нотолгоо их байдаг, гэтэл өмгөөлөгч үйлчлүүлэгчийнхээ эрх ашгийг хамгаалах боломжгүй нөхцөл бүрддэг. Тиймээс энэ үе шатанд холбогдогчийн эрх ашиг хамгаалагдах нөхцөл бүрдэнэ. Прокурор, мөрдөгчийн ажлыг дүгнэх үзүүлэлт тооны араас хөөцөлддөг байдал хуулийн шинэчлэлтэй зөрчилдөөд байна.

Өмгөөлөгч Г.Төгөлдөр:

Эрүүгийн хэргийг шүүхээс буцаах нь зөв. Нийгмийн хандлага бол хэн нэгний бурууг хөөцөлдөөд байна. Эрүүгийн эрх зүй нь үнэн бодит байдлыг тогтоох үүрэгтэй. Прокурор, мөрдөгч мэдлэггүй байна, ажлаа сайн хий гээд байна. Гэтэл процессыг харахаар хэргийн бодит байдлыг шалгаагүй байна гэдгийг шүүгч олж хараад байгаагаас хэргийг буцаах шаардлага тулгарч байна.

Өмгөөлөгч Д.Нямдорж:

Баримт бэхжүүлэх хуульд заасан журам зөрчигдвөл буцаана. Хуулийн дагуу бүрдүүлэх боломж нэмэгдэнэ. Мөрдөн шалгах ажиллагааг нэмж хийлгэх боломж бий болно. Хавтаст хэрэгтэй шүүх дээр ирж л бүрэн танилцдаг. Үйлчлүүлэгчийн ашиг сонирхлыг хамгаалах, эрх зүйн байдлыг дээрдүүлэх тодорхой боломж бий болно.

БУСАД АСУУДАЛ

ЭХХШтХ-ийн 34.7 дугаар зүйл зөрчилдөөнтэй зохицуулалт болсон нь асуудал дагуулж байна. Үүнд:

1. Прокурор шүүгдэгчийг гэм буруугүй гэж үзсэн бол буцаахаар байгаа. Гэтэл өөрөө яллах дүгнэлт оруулж ирчхээд, шүүхийн шатанд "гэм буруугүй" гэж үзэж байгаа нь логикгүй юм.
2. Дараагийн үндэслэл нь хэргийг буцаах шаардлагатай гэж прокурор үзвэл буцаана. Прокурор шүүхийн өмнөх шатанд хэргийг хэрэгсэхгүй болгох боломжтой байж яллах дүгнэлт үйлдэж оруулж ирчхээд "хэргийг буцаах шаардлагатай" гэж шүүхийн шатанд үзэж байгаа нь тун ойлгомжгүй.

ЭХХШтХ-ийн чухал алхам бол "шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг" бөгөөд энэ шатнаас хүний эрхийн зөрчил, техникийн алдааг залруулах боломж олгож буцаах шийдвэр гаргах нь зүйтэй.

ДҮГНЭЛТ

Хуульд залруулах зүйл байгаагийн зэрэгцээ хуульч, хууль сахиулагчдад шинэ хууль тогтоомжийг нэг мөр ойлгуулан таниулах, хуулийг мөрдөж ажиллах эрх зүйн соёлыг төлөвшүүлэх хэрэгцээ шаардлага өндөр байгаагийн илрэл нь өнөөдрийн хэлэлцсэн асуудал байлаа. Шүүхээс хэрэг буцаах асуудлын цаана шүүгдэгч, яллагдагч, нөгөө талд хохирогчийн эрхийн асуудал байгаа тул нухацтай авч үзэх шаардлагатай. Хуульд хийх нэмэлт, өөрчлөлтийг зүйл заалт өөрчлөх төдийгөөр хэсэгчлэн авч үзэх биш харин хүний эрх, хуульт ёсны зарчмын үүднээс цогцоор, нухацтай авч үзэж, бодлогын оновчтой шийдлийг эрэлхийлэх шаардлагатай байна.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ ОРОЛЦОГЧИД

- | | |
|---|--|
| 1. Ж.Батзоригт, МХХ-ны зөвлөлийн гишүүн | 18. Ч.Өнөржаргал, Өмгөөлөгч |
| 2. С.Баянмөнх, Өмгөөлөгч | 19. Д.Пүрэвдорж, Чингэлтэй дүүргийн Ахлах улсын өмгөөлөгч |
| 3. Т.Баярдалай, Өмгөөлөгч | 20. Г.Төгөлдөр, Өмгөөлөгч |
| 4. Л.Баярт, Өмгөөлөгч | 21. Л.Түвшинцэнгэл, Өмгөөлөгч |
| 5. А.Буяндэлгэр, Сонгинохайрхан дүүргийн улсын өмгөөлөгч | 22. Б.Удвал, Хуульч |
| 6. Б.Ганбаатар, МХХ-ны зөвлөлийн гишүүн | 23. Ж.Хунан, МХХ-ны Ерөнхийлөгч |
| 7. Т.Ганбаатар, Мэргэжлийн хариуцлагын хорооны ажлын албаны дарга | 24. А.Энхтөр, Өмгөөлөгч |
| 8. Л.Данзанноров, МХХ-ны зөвлөлийн гишүүн | 25. Б.Энхзаяа, МХХ-ны зөвлөлийн гишүүн |
| 9. С.Дина, Судлаач | 26. Л.Энхсайхан, МХХ-ны Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлсэн хорооны тэргүүн, Өмгөөлөгч |
| 10. Б.Мөнхжаргал, Зөв хөгжил үр дүнт оролцоо ТББ | 27. Г.Эрдэнэ, Судлаач |
| 11. Э.Мягмарцэрэн, Өмгөөлөгч | 28. П.Эрдэнэбаатар, Дотоод хэргийн их сургуулийн багш |
| 12. Г.Наранбаатар, Өмгөөлөгч | 29. Б.Эрдэнэбилэг, МХХ-ны Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээч, сургагч багш |
| 13. Г.Нацаг-Эрдэнэ, 24tsag.mn сэтгүүлч | 30. П.Эрдэнэжаргал, Нээлттэй Нийгэм Форум ТББ-ын гүйцэтгэх захирал |
| 14. Д.Нямдорж, МХХ-ны зөвлөлийн гишүүн | 31. Ж.Эрхэсхулан, МУИС-ийн ХЗС-ийн Доктор, Дэд профессор |
| 15. Л.Ононбаяр, МХХ-ны зөвлөлийн гишүүн, Өмгөөлөгч | |
| 16. Д.Отгонпүрэв, Өмгөөлөгч | |
| 17. Р.Оюунбадам, Шихихутуг их сургуулийн багш | |